



Дэлхийн Нэгдсэн Залбирлын Хөдөлгөөн ньжил бүрийн 2024

VIVA
together for children



Ертөнцийн гэрэл
Дэлхийн Нэгдсэн Залбирлын
Хөдөлгөөн ньжил бүрийн 2024

анилцуулга



Библи анкор. Вива Дэлхийн Нэгдсэн залбирал нь бүхэлдээ хүүхдүүдийн тухай, ялангуяа хүүхдүүдийг хүүхдийн төлөө залбируулах юм. 2024 оны сэдэв нь "Ертөнцийн гэрэл," бөгөөд Иохан 9:5-д Есүс хэлэхдээ "Би ертөнцөд байгаа үедээ ертөнцийн гэрэл байна гэж хариулав". Библийн зангуу нь бүхэлдээ Иохан 9 бөгөөд хараагүй хүний эдгэрэлтийн талаар бичигдсэн байдаг.

Вива хэрхэн эхэлсэн бэ. Вивагийн үүсгэн байгуулагч, Патрик Макдоналд, Өмнөд Америкад илгээлтийн багтай хамт гудамжны хүүхдүүдийн төлөө ажиллаж байх үедээ харсан үзэгдлээ хэлэв. Патрик шөнө маш сүр жавхлантайгаар эргэлдэж буй бөмбөрцгийн зураг харсан ч тэр нь "харанхуй" байв ... Гэтэл гэнэт жижиг, сул, тодорхой бус гэрлийн цоорхойнууд цацарч эхлэсэн. Улам олон болсоор тодорхой газрыг хамарсан гэрлийн төвүүдэд холбогдож эхлэв. Уур амьсгал яагаад ч



К а м б о ж 2023



юм алхам бүрээр өөрчлөгдөж, аажмаар маш хүчтэй, тод болов. Патрик энэ үзэгдлийг "Таны төлөвлөгөө юу вэ? Эзэн минь, та хэрхэн яаж эдгээр хүүхдүүдийн хэрэгцээг хангах вэ? гэсэн асуултанд нь Бурханы өгсөн хариулт гэдгийг мэдэж байжээ. Энэхүү үзэгдэл нь үйл ажиллагаа нь идэвхжсэн, сүлжээнүүдэд холбогдсон, нэгдсэн стандартад нийцүүлэн тоноглогдсон

чуулгануудын дайчилгааг илэрхийлсэн юм. **ГЭРЭЛ!**

Мэдээлэл. Энэхүү эх үүсвэрүүд нь Иохан 9 дээрх түүхийн дөрвөн сэдвийн хамт үйл ажиллагаа, цээжлэх ишлэл болон хүүхдүүдэд бусдыг залбиралд удирдах цагийг нээж өгөх хэрэгжүүлэлтийн асуултуудыг санал болгож байна. 2023 оны нэгдсэн залбиралын гэрчлэлийг багтаасан. Хүүхдийн кино, дуу, PowerPoint танилцуулга болон 28 хоногийн бэлтгэлийг www.worldweekendofprayer.com вэб сайтаас үзэх боломжтой.

Дөрвөн сэдэв

- i) **Бурханы ажил** – бага насны хүүхдүүдэд зориулсан гол анхаарал
- ii) **Та яагаад эргэлздэг вэ?** – том хүүхдүүд ба өсвөр үеийнхэнд зориулсан
- iii) **Есүс гэж хэн бэ?** – өсвөр үеийнхэнд зориулсан
- iv) **Итгэл гэж юу вэ?** – залуучууд болон насанд хүрэгчдэд зориулсан

Хүүхдүүд олон янзаар залбирч болно: гурван хүүхэд хамт залбирах баг үүсгэх; залбирлын мод бүтээх; шааран дээр залбиралаа бичих; жижиг цаасан дээр залбиралаа бичээд наах; олон улсын солилцооны залбирлын бичлэг үзэх.



Дэлхийн Нэгдсэн Залбирлын Хөдөлгөөн ньжил бүрийн 2024

VIVO
together for children

Хүүхдүүдэд зориулсан залбирлын сэдвүүд

- i) Гэр бүлд нь амар тайван ба хайр ирэх.
- ii) Хангалттай идэх хоол хүнс, уух цэвэр ус, өмсөх хувцас, бэртэж гэмтсэн үед эрүүл мэндийн тусламж.
- iii) Амар тайван ба аливаа хүчирхийллийг зогсоох.
- iv) Сургуульд сурч, боловсрол эзэмшиж, эелдэг, хайр татам багш нараар заалгуулах.
- v) Дээрэлхэлтээс болон залилан мэхлэгчдээс хамгаалах хамгаалалт.
- vi) Насанд хүрэгчдийн хүүхдэд хандах хандлагыг өөрчлөх
- vii) Хүүхдүүдийн амьдралыг сайжруулах хүсэл эрмэлзэлтэй сүм, чуулганууд хамтран ажиллах.



Л а т и н А м е р и к 2023

I: Бурханы ажил

- a) **Түүх:**Иохан 9:1-12
- b) Нэгэн өдөр, Есүс шавь нартайгаа явж байхдаа нэгэн гуйлга гуйж буй эрэгтэйг харав.Тэр хүн төрөлхийн хараагүй хүн байв. Шавь нар нь Түүнээс “Рабби хэн нүгэл үйлдсэнээс энэ хүн хараагүй төрсөн юм бэ? Энэ өөрөө юу? Эцэг эх нь үү?” гэж асуусанд Есүс та нар буруу асуулт асууж байна гэв. Харин энэ бол Бурханы үйлсийг түүгээр харуулахын тулд юм. Есүс хэлэхдээ, “Би ертөнцөд байгаа үедээ ертөнцийн гэрэл байна.”Ингэж хэлээд, Тэр газар нулимж, шүлсээрээ шавар зуурч, өнөөх хараагүй хүний нүдэн дээр тавив. Яв Силоамын цөөрөмд угаа гэв.Тэр явж,угаав. Гайхамшиг болов! Тэр одоо харж байна.Хөршүүд нь түүнтэй уулзсаны дараа зарим нь энэхүү гайхамшиг болсонд эргэлзэв.Энэ чинь нөгөө л гуйлга гуйж суудаг хүн байна гэв..
- c) **Үйл ажиллагаа**
 - i) Шавран хөшөө–баримлын шавраар эрэгтэй хүний хөшөө хийх(ж.нь Есүс).Энэ нь хараагүй хүний уулзсан Есүсийг илтгэж байгаа юм. Дараа нь гэрэл юмүү толь толгой дээр нь тавиад Есүс бол энэ ертөнцийн гэрэл гэдгийг харуулаарай. Өөр шавраар хараагүй хүнийг илтгэх хөшөө хийгээрэй.ii) Хараагүй зураг – нүдээ боосон үедээ гэрийнхээ урд байгаа хүний зургийг зураарай (зурахад хэр зэрэг хүнд байгааг ажигла).
- d) **Цээжлэх ишлэл**Иохан9:5“Би ертөнцөд байгаа үедээ ертөнцийн гэрэл байна.”
- e) **Хэрэгжүүлэлт** – Доорх асуултын дагуу ярилцаж Бурханы агуу ажлыг харан бусдыг залбиралд удирдаарай.
 - i)Ямар нэгэн муу зүйл тохиолдох үед Бурхан хэрхэн тэрхүү нөхцөл байдлыг өөрчилж чадах вэ?Бид юу хийх хэрэгтэй вэ?
 - ii)Өөрийнхөө гэрт, найзынхаа гэрт, сургуульдаа өөрчлөлт харсан уу? Энэ өөрчлөлтийн төлөө бид залбирч чадах уу?
 - iii)Хараагүй хүн Есүсд итгээд цөөрөмд нүдээ угаах нь хэцүү байсан.(Тэр ойрхон байгаа усаар угааж болох байсан). Бидний Бурханд итгэх итгэл яах вэ? Бидний асууж буй өөрчлөлтүүд



Дэлхийн Нэгдсэн Залбирлын Хөдөлгөөн ньжил бүрийн 2024

VIVA
together for children

маш их цаг хугацааг шаардаж байгаа юм болов уу? Бид бага ч гэсэн зүйл хийх ёстой юм болов уу?

f) Патна Индиагийн гэрчлэл

2023 оны Дэлхийн Нэгдсэн Залбирал Бурханы бидэнд өгсөн үзэсгэлэнтэй бүтээлийг хамгаалах тэрхүү үүрэг хариуцлагыг маш хүчтэйгээр ойлгуулж чадсан. Сургалтын төвийн охин Анжали шаардлагагүй гэрэл, сэнсүүдийг унтрааж, усны цоргыг хааж, суулгац тарьж, эргэн тойрноо цэвэр цэмцгэр байлгадаг. Тэр одоо байгалийн дайчин, Бурханы бүтээлийн үнэ цэнэтэй асран хамгаалагч, ахан дүүс, найз нараа үргэлж өөртэй нь нэгдэхийг ятгаж, урамшуулж байна.

2:Бурханы гайхамшиг

a) Түүх Иохан 9:13-23

b) Түүнийг эдгээсэн хүн Есүс байсан гэдгийг хөрш нартай хэлэхэд, урьд нь хараагүй байсан хүнийг тэд фарисайчууд дээр авч ирэв. Хараагүй байсан хүн тэд нарт юу болсон талаар тайлбарлав. Зарим удирдагч нар нь түүнийг эдгээхэд ашигласан шавар зууралт нь Амралтын өдөр болсон гэж хэлэв. Амралтын өдөр ямар нэгэн ажил хийх боломжгүй байсан. Эргэлзээ дүүрнээр Фарисайчууд эцэг эхээс нь хүү нь мөн эсэхийг, төрөлхийн хараагүй төрсөн эсэхийг батлахаар асуув. Тэд айж, яаж одоо тэр харж чадаж байгааг асуув. "Тэр одоо нас биед хүрсэн, өөрөс нь асуу" гэж хариулав.

c) **Үйл ажиллагаа** – i) Хүүхдүүд өөрсдийн үгээр энэ түүхийг жүжиглэж үзүүл. Өөр өөр дүрүүдийг аван хоёр удаа жүжиглэ.

1) Дүрийн тоглолт- Хүүхдүүд өөрсдийн үгээр энэ түүхийг жүжиглэж үзүүл. Өөр өөр дүрүүдийг аван хоёр удаа жүжиглэ.

2) Гэрлийн төвүүд-Хүүхдүүдийг баг болгон том ватум цаасан дээр өөрийн улсын газрын зургийг зуруулах. Сүм чуулганы болон сургуулийг хаягыг тэмдэглэ. ЛЭД гэрлийг бүх сургууль ба сүмд холбох.

d) **Цээжлэх ишлэл** Иохан 9:15: "Нүдийг минь Тэр шавраар шавсан. Би угаагаад, тэгээд л харж байна гэв."

e) Хэрэгжүүлэлт

Доорх асуултын дагуу ярилцаж Бурханы гайхамшигийг харахын төлөө бусдыг залбиралд удирдаарай.

i) Хэннэгнээс бидний төлөө ямар нэгэн зүйл хийхийг асуусан үед эргэлзэх нь юугэсэн үг вэ?

ii) Гайхамшиг гэж юу вэ?

iii) Бид нарт гайхамшиг хаана хэрэгтэй вэ? (гэр бүл, сургууль, нийгэмлэг)

f) **Замба дах хүүхдийн гэрчлэл**

"Бурхан энэ дэлхийг, энэ дэлхийн бүхий л зүйлийг бүтээсэн гэдгийг би сурж, амьтдыг хайрлах, халамжлах хариуцлагийг хүмүүст Тэр өгсөн." "Бие биенийхээ төлөө залбирч Бурханд итгэ. Бурханд бүх зүйлээ даатга. Асуудал дунд байсан ч Бурхан чамд тусалж, чамайг чиглүүлэх болно." Бүх Бурханы бүтээлийг харж халамжлах хэрэгтэй. Бүх хүүхдүүд сургуульд сурж боловсрол эзэмших ёстой."



Дэлхийн Нэгдсэн Залбирлын Хөдөлгөөн ньжил бүрийн 2024

VIVA
together for children

3: Бурханы Хүү, Есүс

а) ТүүхИохан9:24-34

Эцэг эхээс нь асуусны дараа, Фарисайчууд өнөөх хараагүй хүнийг хоёр дох удаагаа дуудаад түүнд “Бурханд үнэнийг хэлэн алдрыг өргө. Тэр хүн (Есүс) нүгэлтэйг бид мэднэ.” гэхэд “Тэр хүн нүгэлтэй эсэхийг би мэдэхгүй. Би нэг л юмыг, хараагүй байснаа, одоо харж байгаагаа л мэдэж байна!” гэж хэлэв. Фарисайчууд дахин түүнээс хэрхэн эдгэрсэн талаар асуув. Тэр хариулахдаа, юунд та нар дахин сонсохыг хүсэв? Та нар бас Түүний дагалдагчид болохыг хүсэж байна уу? гэж асуув. Фарисайчууд түүнийг хараан зүхэв. Хараатай болсон хүн Есүсийн талаар улам илүү гэрчилхэд Фарисайчууд түүнийг нүгэл хилэнц дотор төрсөн атлаа бидэнд заах нь уу, чи? гээд синагогоос хөөн гаргав.

б) Үйл ажиллагаа-Хэн хэлсэн бэ?-Хүүхдүүдийг тойрогт цуглуулан, нүдийг нь боо. Нэг хүүхдийг тойргийн төвд зогсохоор сонгож “Яв. Силоамын цөөрөмд угаа” гэж хэлүүл. Тэр хүүхэд буцаад тойрогдоо ороод бусад бүх хүүхдүүд нүдний боолтоо аваад дуу хоолойгоор нь хэн Есүсийн хэсгийн хэлсэнг таалгуул.

Идэж болох шавар- аяган бялуу хийдэг саванд шоколад хий. Нэг нь бусдыгаа халбагаар хооллоно. Тэд нүдэн дээр нь тавих биш, аманд нь хийнэ!

с) Цээжлэх ишлэлИохан9:32-33:

“Төрөлхийнсохорхүнийнүдийгнээснийгцагхугацааныэхлэлээсхойшхэн ч сонсоогүй.ЭнэхүнБурханаасирээгүйюмболТэрюу ч хийжчадахгүйбайхбайсангэлээ.”

д) Хэрэгжүүлэлт

Доорх асуултын дагуу ярилцаж Бурханы Хүү Есүсийг сонсохын төлөө бусдыг залбиралд удирдаарай.

- i) Яагаад зарим хүүхдүүд Есүсийг Бурханы Хүү гэдгийг мэдээд зарим нь мэддэггүй юм бол?
- ii) Есүсийн талаар өөр ямар зүйлсийг мэдэх нь чухал вэ?
- iii) Залбирал нь Бурхантай ярилцах юм бол, бид яаж Бурханыг сонсох вэ? Та одоо Есүсийг сонсож чадаж байна уу?

е) Танзания дах Аснатын гэрчлэл

Аснат 15 настай ба аав ээж нь салсанаас хойш ээжтэйгээ амьдарч байгаа.2022 оны Дэлхийн Нэгдсэн залбиралаар Аснат гэр бүлээрээ эргэн хамт амьдрах талаар залбирсан. Энэ жил, тэр бидэнд “ Би Бурханд өөрийнхөө хүмүүсийг үргэлж халамжилж байгаад нь маш их талархдаг.”Урт хугацааны туршид манай аав ээж хоёр бие биентэйгээ утсаар ч хүртэл холбогдохгүй болтлоо салсан байсан.Өмнө жилийн эцэст тэд бие биенлүүгээ залгаж эхлэсэн. Энэ нь надад хэзээ нэгэн өдөр тэд буцаад нийлнэ гэдэг итгэлийг өгсөн. Бүх алдар нь бидний залбиралд үргэлж хариулт өгдөг Бурханд байг.

4: Бурханд итгэх итгэл

а) ТүүхИохан9:35-41

ИудейчүүдтэрхүнийгхөөнгаргасныгЕсүссонсоод, түүнийголж“ЧиХүнийХүүдитгэжбайнауу?” гэхэд тэр “Эзэнминь, Тэрхэнбэ? БиТүүндитгээгэв.” Есүс “ЧиТүүнийгхарсан. ОдоочамтайяржбайгааньТэрмөнгэлээ.” Тэр “Эзэн, биитгэжбайна”гээдТүүндмөргөв.Есүс тэгээд



Дэлхийн Нэгдсэн Залбирлын Хөдөлгөөн ньжил бүрийн 2024

VIVA
together for children

сүнслэг хараагүйн талаар ярьж Фарисайчууд шиг зарим хүмүүс түүнийг Бурханы Хүү гэдгийг хараад хүлээж авч чаддагүйг хэлэв. Итгэдэггүй хэн ч болов шүүлтэнд орж нүгэлтэй байна.

b) Үйл ажиллагаа

- i) Дуу–Бага насны хүүхдүүдээр хялбар дуу зохиолго.
- ii) Цуглуулга–бага зэргийн даавуу, өнгийн цаас, багц будгаар асар том цуглуулга хийж хананд өлгө. Үүнийгээ хар даавуугаар бүтээ. Хүүхдүүд бүтээсэн цуглуулга руу утсаа ашиглан гэрэл тусгаж Фарисайчууд шиг “Бид бас сохор байх нь уу?” “Даавуугаа холдуул, гэж хэлэхэд Есүсийн хийсэн зүйлсүүд дээр гэрэл тусах үед” “Есүс Би бол энэ ертөнцийн гэрэл” гэж хэл.

Цээжлэх ишлэл Иохан 9:38 Тэр “Эзэн минь, би итгэж байна” гээд Түүнд мөргөв.

Хэрэгжүүлэлт

Доорх асуултын дагуу ярилцаж Бурханд итгэх итгэлийн төлөө бусдыг залбиралд удирдаарай.

- i) Итгэл гэж юу вэ?
- ii) Хараагүй хүнийг хараатай болгосон гэх мэт Есүсийн хийж чадах зүйлүүдийг ойлгон мөн Есүс Бурханы хүү гэх итгэлийг хүмүүс анх олж мэдсэн үед ямар байдаг вэ?
- iii) Есүс биднийгэр, гудамж, сургууль, коллежийн нөхцөл байдлыг өөрчилж чадна гэж табодож байна уу? Түүнийг залбиралд хариулж чадна гэдэгт итгэхийн тулд танд илүү их итгэл хэрэгтэй юу? Яагаад Түүнээс үүнийг хийхийг гуйж болохгүй гэж?

Камбодиа дах хүүхдийн гэрчлэл

Хүүхдүүд хамт залбирах нь маш хүчтэй гэж хэлсэн. Яг л хаан эсвэл хатан шиг том багийн залбирлыг удирдаж байгаа мэт. Сүмийн удирдлагууд ирээдүй үе болсон хүүхдүүдийг дараа дараачийн илгээлтийн хариуцлагатай байдалд бэлэн болгож бэлтгэхийг ойлгосон.

Хаалтын залбирал

Өө Есүс ,та бол энэ ертөнцийн гэрэл юм. Төрхөөсөө харж чаддаггүй байсан хүнийг та эдгээсэн. Энэ бол гайхамшиг. Тэр зөвхөн өөрийнхөө үүргийг гүйцэтгэж Силоамд нүдээ угаасан. Тэр таньд итгэсэн. Надад ч мөн таньд итгэхэд туслаач, Есүс. Фарисайчууд шиг сэтгэхүйдээ сохор биш, харин манай хотын хамгийн ядуухэсэгт байгаа байдлыг өөрчлөхийг Таниас хүлээхэд минь туслаач. Та өөрийнхөө гайхамшигийн гэрлийг миний гэр, гудамж, сургуульд минь тусгаж өгөөч. Би яг тэр сохор хүн шиг "Эзэн би итгэж байна" гэж тунхагласан шиг итгэлтэй байх болтугай. Би таньд хайртай Есүс.

Дэлхийн Нэгдсэн Залбирлын Хөдөлгөөн ньжил бүрийн 6-р сарын эхний Бямба гарагт зохион байгуулагддаг, дэлхийн хэмжээнд олон зуун мянган насанд хүрэгчид болон хүүхдүүдийг нэгтгэдэг санаачилга юм. Вива-гийн санаачилсан, дэлхий даяар 38 олон нийтийн сүлжээтэй, илүү олон хүүхдүүдийн Бурханы өгсөн потенциалыг хөгжүүлж, амьдралыг нь өөрчлөх зорилготой халамжын төв юм. Илүү ихийг www.viva.org- ээс судлаарай.

VIVA
together for children